

Олон Улс Судлал №3, 2014 он: хуудас 157-158.

## **“Монгол-Хятадын хүмүүнлэгийн солилцооны шинэ боломж, шинэ сорилт” эрдэм шинжилгээний симпозиум болов**

Монгол-Хятад улс дипломат харилцаа тогтоосны 65 жил. Бээжингийн их сургуульд Монгол судлалын судалгааны төв байгуулагдсаны 10 жилийн ойд зориулан Бээжингийн их сургуулийн Монгол судлалын судалгааны төв 2014 оны 10 сарын 10-ны өдөр “Монгол-Хятадын хүмүүнлэгийн солилцооны шинэ боломж, шинэ сорилт” олон улсын эрдэм шинжилгээний симпозиум зохион байгуулав.

Тус симпозиумд Хятад улсын Соёлын яамны Гонконг, Макао, Тайваний соёлын асуудал эрхлэх товчооны дарга Жан Айпин, Хятад улсын Боловсролын яамны Олон улсын хамтын ажиллагааны газрын дэд байцаагч Фан Зюнь, Монгол улсад элчин сайдаар сууж байсан элчин сайд Гао Шумао, элчин сайд Хуан Зя Куй, Гадаад харилцааны яамны Азийн хэлтэсийн Монголыг хариуцсан тасгийн эрхлэгч Сун Хунлянь зэрэг Монгол, Хятадын засгийн газрын төлөөлөгчид, судлаачидаас гадна Монгол улсын 60 гаруй оюутан сурагчид оролцов.

Тус симпозиумд БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн судлаач Жалага “Хятад-Монголын хүмүүнлэгийн харилцаа солилцоог шинэ шатанд гаргах тухай”, Олон улсын Монгол судлалын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Д.Төмөртоогоо “Монгол судлалын өнөөгийн байдал”, Монгол улсын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн профессор Н.Ариунгуа “Монгол-Хятадын хүмүүнлэгийн солилцооны шинэ боломж, сорилт”, Монгол улсын хятад судлаач Д.Болдбаатар “Монгол-Хятадын харилцаанд соёлын солилцооны эзлэх байр суурь”, МУИС-ийн Кунзийн институтийн

Монголын талын захирал М.Чимэдцэеэ “Соёл ба орчуулгын соёл”, Өвөр Монголын их сургуулийн профессор Наран “Өвөр Монголоос Монгол улс оруулж буй хөрөнгө оруулалт, худалдаа”. Өвөр Монголын их сургуулийн профессор Түмэнцэцэг “Монголын улсын шашны бодлого хийгээд Хятад-Монголын шашны харилцаа” сэдвээр илтгэл хэлэлцүүлж Хятад-Монголын харилцааны хөгжлийн асуудлыг философи, улс төр, эдийн засаг, соёл, шашны харилцаа зэрэг олон өнцөгөөс авч үзэж хэлэлцэв.